

“Улаанбаатар төмөр зам” ХНН жил бүр Төмөр замын тээврийн салбарын статистикчдын зөвлөгөөнийг зохион байгуулдаг уламжлалттай билээ. Энэ жилийн зөвлөгөөн 2024.06.26-ны өдөр “Ган зам” ресторанд зохион байгуулсан бөгөөд Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний статистикийн хороо, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөр зам”, “Монголиантранс Ложистик” ХХК зэрэг байгууллагуудын дарга, статистикч нар оролцлоо.

Тус зөвлөгөөнд “ГТХЗНТ” УТҮГ-ын хэлтсийн дарга Төмөр замын салбарын статистик мэдээллийг хэрхэн бүрдүүлж, боловсруулж, тайлагнадаг талаар оролцогчдод мэдээлэл хүргэсэн. Төмөр замын тээврийн статистикийн бүрдэлт, статистик өгөгдөл боловсруулалт, программ хангамжийн ашиглалт, шуурхай мэдээ болон хатуу тайлангийн тулгалт зэрэг сэдвээр зөвлөлдөж, тулгамдсан асуудлуудаа ярилцаж хэлэлцлээ.